



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/20.

Зуунмод

Төрийн болон орон нутгийн өмчийн  
эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын  
ажлыг зохион байгуулах  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2.70 дугаар зүйлийн 4.72 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтын хэмжээг тогтоох, дутагдуулсан, бүртгэлгүй орхигдсон, маргаантай, ашиглалтгүй хөрөнгийн судалгааг гаргах, хөрөнгийн чанар байдал, хадгалалт хамгаалалтад дүнэлэлт өгөх тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Бадамгарав (Газрын төлбөр, татвар, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Т.Пүрэвдулам (Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Т.Оюунбаатар (Нярав)

Б.Бат-Эрдэнэ (Жолооч)

Нарийн бичгийн дарга:

Д.Бадамханд (Ахлах нягтлан бодогч)

2. Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлын төлөвлөгөөг батлуулж, зохих хууль дүрмийн дагуу удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Комиссын дарга (Б.Бадамгарав)-т даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАСАНЖАРГАЛ

4132011